



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2024.04.19 № 151
танай -ы № -т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Нэгдсэн удирдамжийн дагуу “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, судалгааг хүргүүлж байна.

Хавсралт 30 хуудас

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Ж.ГАНБААТАР



232430752

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРЧ
ХЭРЭГЖСЭН БОЛОВЧ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ТАВИХ ХЯНАЛТ,
УЛСЫН КОМИССЫН ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА, ӨМЧИД
БҮРТГЭХ АЖЛЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

АУДИТЫН КОД: ХЭА-2024/18-22-ШТА-ГА

“УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-НД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Хэрлэн сум 2024 он



**Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор Ж.Ганбаатар**

Утас: 70562112 Цахим хаяг: ganbaatar@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 92116773 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Эрдэнэбилэг

Утас: 92116770 Цахим хаяг: erdenebilegd@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Билэгсайхан

Утас: 88032817 Цахим хаяг: bilegsaikhants@audit.gov.mn

Аудитор Т.Алтаншагай

Утас: 92116768 Цахим хаяг: altanshagait@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	
БҮЛЭГ А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний баримт бичгийг дүрэм, журамд нийцүүлэн боловсруулсан боловч хяналтын зардлыг бүрэн санхүүжүүлээгүй байна.....	
А.1. Төсөл, арга хэмжээний зураг төсөл, ажлын даалгаврыг холбогдох хууль тогтоомж, норм, дүрмийн дагуу боловсруулсан байна.....	
А.2. Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцож бүрэн хэрэгжихээр баталсан байна.	
А.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид санхүүжилтийг хугацаанд нь бүрэн олгож байгаа хэдий ч захиалагч, зохиогчийн хяналтын зардлыг бүрэн олгохгүй, төвлөрүүлэхгүй зөрчил давтагдсаар байна.....	
БҮЛЭГ Б. Төсөл, арга хэмжээнд тавих хяналт хангалтгүй, орон нутгийн өмчид бүртгэх ажил бүрэн хийгдээгүй байна.	
Б.1. Төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсвийн дагуу хэрэгжсэн бөгөөд дийлэнх төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.....	
Б.2 Зарим төсөл, арга хэмжээнд тавих хяналт хангалтгүй, улсын комиссын бүрэлдэхүүн дутуу ажиллаж байна.....	
Б.3 Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна.....	14
БҮЛЭГ В. Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний дийлэнх нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн боловч зарим ажлуудын үр дүн хангалтгүй байна.	
В.1 Хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар нь ашиглахгүй байна.....	
В.2 Хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.....	
БҮЛЭГ Г. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн байна.....	
Г.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хуульд нийцүүлэн төлөвлөсөн байна.....	
Г.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт бүрэн хэрэгжсэн байна.	
Г.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг санхүүгийн тайланд бүрэн бүртгээгүй байна.....	
Холбогдох байгууллагын санал:	
ДҮГНЭЛТ: 23	
ЗӨВЛӨМЖ:	

	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДҮАХ	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗҮ	Зөвлөх үйлчилгээ
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТХОХТАХТСХТ	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХА	Харьцуулалтын арга
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ШХА	Шууд худалдан авалт

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Эрх шилжүүлсэн 33 төсөл арга хэмжээний ангилал	7
Дүрслэл 2	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ангилал	7
Дүрслэл 3	Батширээт сумын сургуулийн дотуур байрны барилгын улсын магадлалын дүгнэлт	9
Дүрслэл 4	Төсөл, арга хэмжээний мэдээлэл	11
Дүрслэл 5	Төсөл, арга хэмжээний бүртгэлийн мэдээлэл	15
Дүрслэл 6	Төсөл, арга хэмжээний зураг	17

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Бүртгэлд тусгах мэдээлэл	14
Хүснэгт 2	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын дүн	18
Хүснэгт 3	Дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал	19

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн гүйцэтгэлийн аудитыг хийлээ.
Аудитын зорилт	“Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, Үндэсний аудитын газар болон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: ➤ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх, ➤ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хүлээн авсан эсэх, ➤ Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх ➤ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн ИТХ, аймгийн ЗДТГ, аймгийн ОНӨГ, аймгийн ГХБХБГ болон гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, ХАА-ны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэлээ.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд аудитын стандарт АДБОУС-100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-7:2020, Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ан зарчим, арга зүй, Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа хэрэгжүүлж, аудитыг ахлах аудитор Д.Эрдэнэбилэг ахлан, ахлах аудитор Ц.Билэгсайхан, аудитор Т.Алтаншагай нар

**Хүндрэл
бэрхшээл**

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 02 дугаар сарын 05-аас 03 дугаар сарын 30-ны өдрүүдэд гүйцэтгэн, тайлагналын үе шатыг 04 дүгээр сарын 19-ны өдөр хүртэл хугацаанд гүйцэтгэв.

.....


ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар Хэнтий аймагт 828,359.5 сая төгрөгийн 93 төсөл, арга хэмжээг баталж, орон нутагт 190,784.8 сая төгрөгийн 33 төсөл, арга хэмжээг эрх шилжүүлэн хэрэгжүүлжээ.

Үүний 32 нь өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж буй, тухайн оноос эхлэн хэрэгжих 1, нийт 190,784.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 33 төсөл, арга хэмжээг 2023 онд 92,798.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Нийт санхүүжилтийн 88 хувийг 29 барилга, байгууламжийн, 9 хувийг 3 их засварын, 3 хувийг 1 тоног төхөөрөмжийн арга хэмжээнд зарцуулахаар тусгажээ. Мөн нийт 32 төсөл, арга хэмжээг 2023 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөжээ.


Дүрслэл 1. Эрх шилжүүлсэн 33 төсөл, арга хэмжээний ангилал



Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдэд 2023 онд 92,798.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 88.3 хувь буюу 81,967.9 сая төгрөгийг санхүүжүүлжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийтдээ 10,565.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 50 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ. Үүний 53,5 хувийг 9 барилга, байгууламжийн, 30,4 хувийг 23 их засварын, 12,9 хувийг 10 тоног төхөөрөмжийн, 3,2 хувийг 8 зураг төсвийн арга хэмжээнд зарцуулахаар тусгажээ. Мөн нийт 32 төсөл, арга хэмжээг 2023 онд хэрэгжүүлж дуусгах ба тайлант онд 10,194.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Дүрслэл 2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ангилал



БҮЛЭГ А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний баримт бичгийг дүрэм, журамд нийцүүлэн боловсруулсан боловч хяналтын зардлыг бүрэн санхүүжүүлээгүй байна.

А.1. Төсөл, арга хэмжээний зураг төсөл, ажлын даалгаврыг холбогдох хууль тогтоомж, норм, дүрмийн дагуу боловсруулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжих 33 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн.

Орон нутагт эрх шилжсэн ажлаас 20 төсөл, арга хэмжээ нь барилга, 6 төсөл, арга хэмжээ нь инженерийн шугам сүлжээ, 2 төсөл, арга, хэмжээ нь авто зам, 2 төсөл, арга хэмжээ нь гадна тохижилт, шугам сүлжээ, 3 төсөл, арга хэмжээ нь их засвар байна.

Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 3.4, 3.5 дахь хэсэгт заасны дагуу архитектур төлөвлөлтийн даалгаврыг аймгийн ерөнхий архитектораар, зургийн даалгаврыг аймгийн Засаг даргын орлогч, холбогдох сумдын Засаг даргаар батлуулсан байна.

Нийт 23 төсөл, арга хэмжээнд архитектур төлөвлөлтийн даалгавар, 14 төсөл, арга хэмжээнд зургийн даалгаврыг баталсан бол Баян-Овоо, Дадал сумын төвийн ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн зургийг БХБЯ-ны албан бичгийг үндэслэн боловсруулжээ.

Мөн Сумын төвийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөл, шинэчлэл /Хэнтий, Баян-Овоо сум/, "Монголын нууц товчоо" цогцолборын барилгын гадна цахилгаан хангамжид 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 10/04 кВ-н хүчдэлтэй 250 кВ-н чадалтай дэд станц /Хэнтий, Дэлгэрхаан сум/ -ын зураг төслийг олгосон техникийн нөхцөлийг үндэслэн боловсруулсан байна.

Барилгын тухай хуулийн 22 дугаар зүйлийн дагуу төсөл, арга хэмжээнд дулаан цэвэр, бохир ус, цахилгаан, харилцаа, холбоо, дохиолол зэрэг шаардлагатай холбогдох техникийн нөхцөлийг авсан байна.

Зураг төслийг Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл, боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 4.3 дахь хэсэгт заасны дагуу 41 барилга, байгууламжид зураг төслийг боловсруулан ажилласан байна.

төгрөг, зохиогчийн хяналтын зардалд 581.1 сая төгрөг, зураг төсвийн зардалд 476.4 сая төгрөг, нормчлолын санд 103.7 сая төгрөгийг шилжүүлж, алданги тооцсон 8.2 сая төгрөгийг бусад орлогын данс, чанарын болон гүйцэтгэлийн барьцаа нийт 11,042.6 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд тус тус байршуулсан байна.

Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн хүрээнд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай “Захиалагчийн чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ”-г байгуулан захиалагчийн техник хяналтыг Барилгын тухай хуулийн 37.2¹-т заасны дагуу гүйцэтгүүлсэн байна.

Энэхүү гэрээнд захиалагчийн хяналтын зардлын 30 хувийг захиалагч /Хэнтий аймгийн ЗДТГ/ тал, 70 хувийг хэрэгжүүлэгч /Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар/ талд гүйцэтгэлийн маягт, захиалагчийн хяналтын тайланг үндэслэн олгохоор заасан байна. Гэрээний дагуу хэрэгжүүлэгч талд 631.1 сая төгрөг, захиалагч талд 225.9 сая төгрөгийг олгосон байна. Захиалагчийн хяналтын зардлаас үлдсэн 24 төсөл, арга хэмжээний 340.0 сая төгрөгийг аймгийн захиалагчийн хяналтын зардалд шилжүүлсэн бол үүнээс 20 төсөл, арга хэмжээний 269.8 сая төгрөгийн хяналтын зардал нь хэрэгжиж дууссан ажлынх байна.

Зохиогчийн хяналтын зардалд 581.1 сая төгрөгийг олгохоос 33 төсөл, арга хэмжээний зохиогчийн хяналтын тайлан, гүйцэтгэлийн баримт бичгийг үндэслэн 467.3 сая төгрөгийг олгож, 11 төсөл, арга хэмжээний 113.8 сая төгрөгийг аймгийн захиалагчийн хяналтын зардлын дансанд шилжүүлсэн байна. Үүнээс хэрэгжиж дууссан 8 төсөл, арга хэмжээний 66.8 сая төгрөг байна.

Аймгийн захиалагчийн хяналтын зардлын данснаас 7 төсөл, арга хэмжээний 200.0 сая төгрөгийг аймгийн бусад орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар аймгийн захиалагчийн хяналтын зардлын дансанд захиалагчийн хяналтын 69.8 сая төгрөг, зохиогчийн хяналтын 66.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь заалтыг мөрдөж ажиллаагүйтэй холбоотой байна.

Эрх шилжсэн төсөл арга, хэмжээнээс барилга, байгууламжийн 38, их засварын 3 төсөл, арга хэмжээ байгаа бөгөөд барилга, байгууламжийн ажлын гүйцэтгэгчид 68,251.6 сая төгрөг, их засварын ажлын гүйцэтгэгчид 307.2 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлийн маягт, баримт бичгийг үндэслэн хугацаанд нь олгосон байна.

¹ Барилга захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий төрийн өмчит хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх, эсхүл холбогдох чиглэлээр бүртгүүлсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуулийн этгээдийг сонгон ажиллуулж болно. (Энэ заалтыг Засгийн газрын 2018 оны 316 дугаар тогтоолоор нэмж, Засгийн газрын 2021 оны 343 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан) ... ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоол “Барилгын ажлын захиалагчийн дүрэм/

Захиалагч болон зохиогчийн хяналтын зардлын хувьд гүйцэтгэлийн маягт, хяналтын тайланг үндэслэн олгож байгаа бөгөөд тайланг ирүүлж гүйцэтгэл баталгаажуулж байгаа хугацаанаас үл хамааран санхүүжилтийн эрх тавигдсанаас хойш дараагийн гүйцэтгэлтэй хамтатган олгож байгаа нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолын 2.3.2.5²-д заасныг мөрдөхгүй байна.


Нормчлолын сангийн зардлыг гүйцэтгэл бүрд баталгаажуулж байгаа хэдий ч тус сангийн зардлыг тухай бүр шилжүүлэхгүйгээр оны эцэст бөөнд нь шилжүүлэх байдал төсөл, арга хэмжээ бүрд байна.

БҮЛЭГ Б. Төсөл, арга хэмжээнд тавих хяналт хангалтгүй, орон нутгийн өмчид бүртгэх ажил бүрэн хийгдээгүй байна.

Б.1. Төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсвийн дагуу хэрэгжсэн бөгөөд дийлэнх төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд эрх шилжсэн 212,114.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 33 төсөл, арга хэмжээнээс зарим ажлыг багцад хуваан 41 төсөл, арга хэмжээ болгон хэрэгжүүлжээ.

Дүрслэл 4. Төсөл, арга хэмжээний мэдээлэл



Тайлант хугацаанд 129,127.7 сая төгрөгийн 31 ажил бүрэн хэрэгжиж дууссан бол 82,986.7 сая төгрөгийн 10 ажил дуусаагүй байна. Эдгээрээс гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн барилга угсралтын 13 төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг сунгасны 1 ажилд гүйцэтгэгчийн албан хүсэлтээр, 3 ажилд үнийн өсөлт болон магадлалын өөрчлөлтөөр, 3 ажилд Дэд бүтцийн ажлын зөвлөлийн шийдвэрээр, 6 ажилд төсвийн хөрөнгө оруулалтын журмыг ашиглан сунгажээ.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээнд тусгасан байгалийн давагдашгүй хүчин зүйл, захиалагч төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй, дүрэм журмын өөрчлөлт нь ажил гүйцэтгэхэд нөлөөлөхөөр байвал, шаардлагатай зөвшөөрөл гараагүй гэх мэт нөхцөлүүдэд хамаарахгүй шалтгаанаар гэрээг сунгасан, хийгдэж буй ажил гэрээний хугацаанд дуусахгүй нөхцөлийг үүсгэсэн байна.

² /2.3.2.5. барилга байгууламжийн зураг төслийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт бичиг, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх; ЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоол. ТХОХТАХТСХТ журам /

Аймгийн Засаг дарга нь Барилгын тухай хуулийн 35.1³, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 7.2⁴, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60.1.1⁵-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хуулийн хүрээнд шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай ажлын хэсэг байгуулж болох боловч тухайн ажлын хэсэг нь шийдвэр гаргахгүйгээр Засаг даргад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх чиглэлээр ажиллах нь зүйтэй юм.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 41 төсөл, арга хэмжээ улсын магадлалаар батлагдсан зургийн дагуу хийгдсэнээс ашиглалтад оруулсан 4 төсөл, арга хэмжээний хийгдээгүй ажлуудыг үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авсан. Үүнд:

Баянмөнх сумын Спорт цогцолборын барилгын агааржуулалт хийгдээгүй, шалны лакан давхаргыг будаагүй, волейбол болон сагсны тоноглолыг суурилуулаагүй,

Өмнөдэлгэр сумын ЕБС-ын шинэ барилгын цахилгааны зарим разеткууд цахилгаанд холбогдоогүй, угаалтуурын холбогчийг сул холбосон, биеийн тамирын залны таазнаас дусаал гоождог,

Бэрх тосгоны Олон улсын стандартын сургуулийн барилгын гадна авто машины зогсоол, сагсан бөмбөгийн талбайн зураасан тэмдэглэгээнүүд хийгдээгүй

Дэлгэрхаан сумын Цэвэр усны эх үүсвэрийн худгийг хамгаалалтын хашааны гадна гаргасан зэрэг зөрчлүүд илэрсэн.

Мөн талбарын ажлаар сумдад ажиллахад орон нутагт эрх шилжиж ирээгүй Өмнөдэлгэр сумын Соёлын төвийн барилгын хананд өгсөн цууралт нь барилгыг ашиглахад хүндрэлтэй байдлыг үүсгэсэн, Батноров сумын ЕБС-ын барилгын ангиудын хаалгыг зураг төсөвт тусгаснаас өөрчлөн босготой болгосон нь хүүхдүүд орж гарахад хүндрэлтэй болсон, спорт залны цонхны материалыг өөрчилж вакум цонх болгосон, Хэрлэн сумын 1 дүгээр багийн дундуур тавьсан А0501 дүгээр зам нь дуусаагүй байхдаа эвдрэл өгсөн зэрэг зөрчлүүд илэрч байгаа нь тухайн ажлуудад захиалагчийн хяналт үр дүнгүй хийгдсэнтэй холбоотой.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа 41 төсөл, арга хэмжээг 2023 оны төсвийн тухай хуульд батлагдсан төсөвт багтаан гүйцэтгэсэн бөгөөд дээрх ажлуудад тоног төхөөрөмж худалдан авах ажил тусгагдаагүй байна.

³ 35.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

⁴ 7.2.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг улсын түвшинд үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбарын түвшинд тухайн салбарын сайд, тухайн салбарын төрийн захиргааны байгууллагын дарга, орон нутгийн түвшинд аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нар удирдана.

⁵ 60.1.Аймгийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

60.1.1.хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах;

Б.2 Зарим төсөл, арга хэмжээнд тавих хяналт хангалтгүй, улсын комиссын бүрэлдэхүүн дутуу ажиллаж байна.

ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ийн 4.7.5 “Гэрээний хугацааг тухайн жилийн төсвийн тухай хуулиар баталсан эхлэх, дуусах хугацааны дагуу гэрээнд тусгах бөгөөд тухайн төслийн санхүүжилт хийгдэж дуусах хүртэл гэрээний дуусах хугацаа хүчинтэй байна” заалтыг үндэслэн 13 төсөл, арга хэмжээний гэрээг сунгасан байна.

Ийнхүү сунгасан гэрээнд гэрээний дуусах хугацаа болон бүтээн байгуулалтын дуусах хугацаа зэргийг тусад нь тусгаагүйгээс дээрх төсөл, арга хэмжээнүүд нь тендерт шалгарсан календарчилсан хугацааг мөрдөхгүй байх, ашиглалтад оруулах хугацаа хойшлох зэрэг зөрчлүүд үүсэж буй тул гэрээний хугацааг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Гэрээний сунгалт хийгдсэн төсөл, арга хэмжээнээс 7 ажил 2023 онд дуусаагүй бөгөөд гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудаас 2023 онд 22 төсөл, арга хэмжээ дуусаж ашиглалтад оруулах улсын комисс ажилласан боловч тус комиссын бүрэлдэхүүн бүрэн бүрдээгүйгээс 4-13 төсөл, арга хэмжээнд зарим гишүүд ажиллаагүй байна.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисст эрчим хүчний хяналтын улсын байцаагч 13, ХБИ-ийн төлөөлөл 10, архивын тасгийн ажилтан, эрүүл ахуйн байцаагч, гамшгийн хяналтын улсын байцаагч 4, барилга техникийн хяналтын улсын байцаагч нар 6 төсөл, арга хэмжээг хүлээн авахад ажиллаагүй байна.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас улсын комиссын гишүүдэд мэдэгдэл хүргүүлдэг боловч тухай цаг хугацаанд албан томилолттой, ээлжийн амралттай, ажил давхардсан зэрэг шалтгааны улмаас бүрдэж ажиллаагүй бөгөөд шалтгаан нөхцөлийг тогтоосон баримтыг бүрдүүлээгүй байна. Иймд улсын комисс дутуу бүрэлдэхүүнтэй ажилласнаас болж зөрчил дутагдал гарч байгаа тул цаашид Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан журмын 7.4 дэх хэсгийг баримталж барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын гишүүдийг бүрэн бүрдүүлж ажиллах шаардлагатай.

Улсын комиссоос үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авсан 4 төсөл, арга хэмжээний зарим ажлууд хийгдээгүй бол бусад төсөл, арга хэмжээнд улсын комиссын гишүүдээс гарсан үүрэг даалгаврыг биелэлтийн хуудсаар хэрэгжилтийн талаар тэмдэглэсэн байна.

Бэрх тосгоны ЕБС-ын сагсны талбайг будах, ус зайлуулах суваг хийх, ногоон байгууламж хийх, Баянмөнх сумын спорт цогцолборын

агааржуулалтыг суурилуулах, шалыг лакдах болон волейболын тор суурилуулах, сагсны шийд байрлуулах ажил хийгдээгүй байна.

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг бүрэн биелүүлсэн ба үүрэг даалгаврын хуудсанд биелэлтийг тэмдэглэн хадгаламжийн нэгж үүсгэн аймгийн архивын тасагт шилжүүлсэн байна.

Харин төрийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо хангалтгүй байгаагаас зарим дууссан төсөл, арга хэмжээний хадгаламжийн нэгжийн хувийг ашиглагч байгууллагад өгөөгүй байна.

Б.3 Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж дууссан 28 төсөл, арга хэмжээг санхүүгийн тайлан бүртгэлд тусгах талаар 2024 оны 1 дүгээр сард аймгийн ЗДТГ болон аймгийн ОНӨГ-аас албан тоотоор холбогдох сумд болон байгууллагуудад хүргүүлсэн боловч зарим төсөл, арга хэмжээг ямар байгууллага, хэдэн төгрөгөөр бүртгэх нь тодорхойгүйгээс бүртгэлд тусгагдахгүй орхигдох асуудал үүсэж байна.

Хүснэгт 1. Бүртгэлд тусгах мэдээлэл

№	Төсөл, арга хэмжээний нэр	Санхүүжүүлсэн дүн	Данс бүртгэлд тусгах байгууллага
1	“Монголын нууц товчоо” цогцолборын барилгын интерьер, гадна тохижилт, гадна шугам сүлжээ /Хэнтий, Дэлгэрхаан сум/ Багц-1	566,510,833.0	Дэлгэрхаан сум
2	“Их хуралдай” цогцолборын барилгын зоорины ажил, гадна тохижилт, шугам сүлжээ /Хэнтий, Биндэр сум/ Багц-1	529,472,528.0	Биндэр сум
3	“Их хуралдай” цогцолборын барилгын зоорины ажил, гадна тохижилт, шугам сүлжээ /Хэнтий, Биндэр сум/ Багц-2	2,336,540,028.0	Биндэр сум
4	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хэнтий, Баян-Адарга сум/	2,482,691,863.0	Баян-Адарга сум
5	“Их засаг-Шихихутаг” цогцолборын интерьер /Хэнтий, Норовлин сум/	826,907,443.0	Норовлин сум
6	Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Баян-Овоо/	5,326,953,551.0	Баян-Овоо сум
7	Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Дадал/		Дадал сум
8	Сумын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ нэмэлт ажил гүйцэтгэх гэрээ /Дэлгэрхаан/	182,299,230.0	Дэлгэрхаан сум
9	Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ /Мөрөн/	997,992,758.0	Мөрөн сум
10	Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ /Баянхутаг/		Баянхутаг сум
11	Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ /Дэлгэрхаан/		Дэлгэрхаан сум
12	Сумын төвийн гадна цэвэр усны шугам сүлжээ	459,075,710.0	Жаргалтхаан сум

	/Хэнтий, Жаргалтхаан сум/		
13	Цэвэр усны гадна шугам сүлжээ /Хэнтий, Өмнөдэлгэр сум/	1,549,902,991.0	Өмнөдэлгэр сум
14	Спорт цогцолборын барилга /Хэнтий, Баянмөнх сум/	1,849,998,730.0	Баянмөнх сум
15	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3.5 км /Хэнтий, Дадал сум/	5,606,948,919.0	Дадал сум
16	Цэвэр усны шугам сүлжээ /Хэнтий, Өмнөдэлгэр сум/	159,197,009.0	Өмнөдэлгэр сум
		22,874,491,593.0	

Аймгийн ОНӨГ-аас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээг санхүүгийн тайланд бүртгэх талаар албан тоот хүргүүлэхдээ байгууллагыг тодорхойлоогүй "сумдад" гэж ерөнхий байдлаар бичиж хүргүүлсэн 16 төсөл, арга хэмжээг ямар байгууллага бүртгэлдээ авах нь тодорхойгүй байгааг харуулж байна.

Тайлант оны жилийн эцсийн байдлаар 83,173.4 сая төгрөгийн 22 төсөл, арга хэмжээг санхүүгийн тайлан бүртгэлд тусгасан боловч 1,627.1 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу бүртгэсэн байна. Харин 27,358.7 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээ бүртгэгдээгүй байна.

Дүрслэл 5. Төсөл, арга хэмжээний бүртгэлийн мэдээлэл



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 28,985.8 сая төгрөгийн дүнтэй 14 төсөл, арга хэмжээг дутуу буюу бүрэн бүртгэлд тусгаагүй байна. Үүнээс 2023 оны төсвийн тухай хуульд 20,798.0 сая төгрөгөөр батлагдсан Хан Хэнтий чуулгын барилгыг хөрөнгөд бүртгээгүй байна.

Нийт нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй төсөл, арга хэмжээнээс 6 нь улсын комиссын акт болон бусад баримт бичиг ирээгүй тул, 3 нь үнийн өсөлтийн зөрүүл бүртгэх шийдвэр ирээгүйгээс, 1 нь ТӨБЗГ-аас шийдвэр ирээгүй, 1 нь тухайн төсөл, арга хэмжээг хэсэгчлэн хүлээн авсан, бусад 3 төсөл, арга хэмжээ нь төслийн нэгжид бүртгэх боломжгүй, мэргэжлийн байгууллагад шилжүүлэхээр хүлээгдэж байгаа, дутуу бүртгэсэн зэрэг шалтгаантай байна.

БҮЛЭГ В. Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний дийлэнх нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн боловч зарим ажлуудын үр дүн хангалтгүй байна.

В.1 Хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар нь ашиглахгүй байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хийгдсэн 41 төсөл, арга хэмжээнээс бүрэн хийгдэж дууссан 123,468.1 сая төгрөгийн 31 ажил байна. Эдгээр ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарсан төсөл, арга хэмжээнээс 4 ажлын

гүйцэтгэл хангалтгүй хийгдсэн, 6 төсөл, арга хэмжээг бүрэн хүчин чадлаар нь ашиглах байдал хангалтгүй байна. Үүнд:

- Баянмөнх сумын Спорт цогцолборын барилга. 2023 оны 11 сарын 27-ны өдөр байнгын ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарсан боловч агааржуулалтын систем, шалны лакан давхарга хийгдээгүйгээс бүрэн ашиглалтгүй.
- Өмнөдэлгэр сумын ЕБС-ын шинэ барилгын цахилгааны зарим залгуурууд цахилгаанд холбогдоогүй, угаалтуурын холболтуудыг сул холбосон, биеийн тамирын заалны таазнаас дусаал гоождог, ширээ сандлын хүрэлцээгүй байдлаас 3 давхар нь ашиглалтгүй.
- Дэлгэрхаан сумын Цэвэр усны эх үүсвэрийн худгийг хамгаалалтын хашааны гадна гаргасан.
- Биндэр сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын гадна цахилгааны холболтыг эрчим хүчний сайдын 2023 оны 10 сарын 25-ны өдрийн А/237 тоот тушаалаар⁶ холболт хийгдээгүйгээс гал тогооны тоног төхөөрөмжийг ашиглах боломжгүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Мөн сумдад шинээр хийгдсэн цэвэр усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг тогтоогоогүй, шинээр гаргасан худгийг цэвэр усны усан сангийн хашааны гадна гаргасан нь Усны тухай хууль⁷ болон түүнд нийцүүлэн гаргасан журмын⁸ хэрэгжилтийг хангахгүй байна.

Баянмөнх сумын спорт цогцолборын барилгын ажлыг гүйцэтгэгч Си эйч би жи констракшн ХХК нь календарчилсан төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн ажлаа хугацаанд нь гүйцэтгээгүй, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Өмнөдэлгэр сумдын гадна цэвэр усны шугам сүлжээний ажилд зураг төсөв боловсруулах даалгаварт тусгасан аж ахуйн нэгж болон төрийн байгууллагуудын холболт хийх ажлыг иж бүрэн төлөвлөж батлуулаагүй, Их хуралдай цогцолборын үндсэн эзэмшигч одоог хүртэл тодорхойгүй байгаа зэрэг шалтгаанаар нийт 6 төсөл, арга хэмжээг бүрэн хүчин чадлаар нь ашиглахгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

⁶ Эрчим хүчний хангамжийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангах зорилгоор нэгдсэн сүлжээнд болон төвлөрсөн дулаан хангамжийн системд сэлгэн залгах, шинээр холболт хийх үйл ажиллагааг 2023 оны 11 сарын 1-ээс 2024 оны 03 сарын 1-ний өдөр хүртэл зогсоосон.

⁷ Усны тухай хуулийн 12.1.4. “усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж, хамгаалах, тохижуулах, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах” 13.1.6. “усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж, бүсийн дэглэмийг мөрдүүлэх”.

⁸ Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын 2.3.4. “Хот суурин газрын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй, үерийн хамгаалалтын далангаас 100 метрээс доошгүй зайд”;

Дүрслэл 6. Төсөл, арга хэмжээний зураг



Мөн талбарт ажиллах явцад эрх шилжиж ирээгүй ажил болох Өмнөдэлгэр сумын Соёлын төвийн барилгын хананд өгсөн цууралт нь барилгыг ашиглахад хүндрэлтэй байдлыг үүсгэсэн, Батноров сумын ЕБС-ын барилгын хаалгыг зураг төсөвт тусгаснаас өөрчилж босготой хаалга суурилуулсан нь хүүхдүүд орж гарахад хүндрэлтэй болсон, спорт залны цонхны хийцлэлийг өөрчилж вакум цонх болгосон, 2019 оны 11 сарын 8-ны өдөр ашиглалтад оруулах дүгнэлт гарсан Өмнөдэлгэр сумын уурын зуухны барилга нуралт өгөх эрсдэлтэй байгаагаас ашиглах боломжгүй байгаа зэрэг зөрчлүүд илэрлээ.

В.2 Хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.

Тус онд хэрэгжиж дууссан 31 төсөл, арга хэмжээний 26 ажил төлөвлөсөн үр дүнд хүрч бүрэн ашиглалтад орсон бол 5 төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна. Үүнд:

Өмнөдэлгэр сумын ЕБС-ийн барилгын ажлыг төлөвлөхдөө ширээ сандлыг шийдвэрлээгүйгээс сургуулийн 3 давхар ашиглалтгүй, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Өмнөдэлгэр сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах даалгаварт тусгасан аж ахуйн нэгж, төрийн байгууллагууд руу цэвэр ус холбох ажил хийгдээгүй, Баянмөнх сумын Спорт цогцолборын барилгын зарим ажил хийгдэж дуусаагүйгээс ашиглалт хангалтгүй байна.

Эрх шилжээгүй Батноров сумын ЕБС-ийн барилгыг анх төлөвлөхдөө спорт заал, урлаг заалны тавилга тоног төхөөрөмжийг бүрэн оруулж төлөвлөөгүйгээс хөрөнгө оруулалтын өгөөж буурч байна.

Хэнтий аймагт эрх шилжүүлсэн 41 төсөл, арга хэмжээг Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичиг, хөрөнгө оруулалтын 2021-2025 оны хөтөлбөртэй уялдуулан төлөвлөж тусгасан байна.

БҮЛЭГ Г. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн байна.

Г.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хуульд нийцүүлэн төлөвлөсөн байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 06 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, их засварын төсөл арга хэмжээг баталж, 2023 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоол, 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 07 дугаар тогтоолоор 2 удаа тодотгол хийн 21,994.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 50 төсөл, арга хэмжээг 10,680.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Хүснэгт 2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын дүн

сая.төгрөг

ИТХ-ын тогтоол	Хөрөнгө оруулалтын дүн	Их засварын дүн	Нийт
2022.12.05-ны №06	5,876.3	2,945.3	8,821.6
2023.03.09-ны №02	6,446.0	2,945.3	9,391.3
2023.07.03-ны №07	7,541.0	3,139.7	10,680.7

Эдгээр төсөл, арга хэмжээний 17 ажил нь өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих бол 33 ажлыг шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Нийт төсөл, арга хэмжээнээс 3 ажлыг 7 багц болгон задалж нийт 54 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлжээ.

Хэнтий аймгийн музейн үзүүлэг дэглэлт хийх ажлыг 2 багц, Эрүүл мэндийн тоног төхөөрөмж ажлыг 3 багц, Нэгдсэн эмнэлгийн яаралтай хүлээн авах хэсгийн засвар ажлыг 2 багц болгосон байна.

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний ангиллаар авч үзвэл барилга, байгууламж 9, их засвар 24, тоног төхөөрөмж 13, зураг төсөл 8 тус тус байна.

Төсөл, арга хэмжээг Хэнтий аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй нийцүүлэн төлөвлөсөн байна.

Дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байдлыг харуулбал:

Хүснэгт 3. Дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал

д/д	Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Хэнтий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	Төсөл, арга хэмжээний тоо
1	АЗДҮАХ 2.1.10	Зорилт 2.2	1
2	АЗДҮАХ 2.1.9	Зорилт 2.2	6
3	АЗДҮАХ 2.4.11	Зорилт 2.4	1
4	АЗДҮАХ 2.4.3	Зорилт 5.2	9
5	АЗДҮАХ 2.5.6	Зорилт 1.4	4
6	АЗДҮАХ 3.3.6	Зорилт 8.3	1
7	АЗДҮАХ 3.5.9	Зорилт 4.2	2
8	АЗДҮАХ 5.1.4	Зорилт 2.4, 7.2	1
9	АЗДҮАХ 5.1.5	Зорилт 2.4, 7.2	1
10	АЗДҮАХ 5.1.6	Зорилт 2.4, 7.3	6
11	АЗДҮАХ 6.1.6	Зорилт 2.1, 8.1	18
12	АЗДҮАХ 6.1.7	Зорилт 8.1	4

Харин Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэхийг үзэхэд Бэрх тосгоны орон сууцын байруудын дээврийн их засварын ажил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.2⁹ -т заасныг баримтлаагүй боловч тус арга хэмжээ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулиас өмнө хэрэгжиж эхэлсэн байна.

Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан барилга, байгууламж, их засварын 33 төсөл, арга хэмжээ нь зураг төслийг боловсруулан магадлалаар баталгаажсан байна.

Г.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт бүрэн хэрэгжсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнээс 2023 онд 23 төсөл, арга хэмжээг шилэн дансны цахим санд мэдээлсэн байна.

Тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 12,527.0 сая төгрөгийн 31 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2023 онд зохион байгуулжээ. Үүний 11.955.3 сая төгрөгийн 19 төсөл, арга хэмжээг НТШ-ын журмаар, 337.7 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг ХА-аар, 194.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг ЗҮ-ээр зохион байгуулсан бол 40.0 сая төгрөгийн 2 ажлыг ШХА-аар зохион байгуулсан байна.

Эдгээрээс 11 ТАХ дахин тендер зарласан бол худалдан авах ажиллагааны дүнд 632.5 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гарсан байна. Нийт худалдан авах ажиллагаанд маргаан гараагүй байна.

⁹ хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ;

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжсэн нийт 50 төсөл, арга хэмжээнээс 32 төсөл, арга хэмжээнд аймгийн ГХБХБГ захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн бол бусад төсөл, арга хэмжээ нь зураг төсвийн болон тоног төхөөрөмж нийлүүлэх ажил тул захиалагчийн хяналт хэрэгжүүлэхгүй ажлууд байна.

Дээрх нийт төсөл, арга хэмжээнүүд нь батлагдсан зураг, төсвийн дагуу хийгдэж байгаа эсэхэд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн бөгөөд нийт төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Дээрх ажлуудаас “Ханбүргэдэйн уулзвараас Хэрлэн голын гүүр хүртэлх зам”-ын 1 дүгээр багийн замын уулзварын асфальтан хучилтад эвдрэлийг гүйцэтгэгч аж ахуйн нэгж баталгаат хугацаанд 2024 онд засварлахаар төлөвлөсөн байна.

Нийт төсөл, арга хэмжээний 48 нь буюу 96 хувь нь бүрэн дуусаж ашиглалтад оруулсан байна. Үүний 11 нь 2022 онд ашиглалтад орсон бол 37 нь 2023 онд бүрэн дууссан байна. Дээрх ажлууд нь батлагдсан зураг төсвийн дагуу хийгдсэн бол 2 ажил бүрэн дуусаагүй тул улсын комисс ажиллаагүй байна.

Биндэр сумын Баян-Өндөр багийн төвийн барилгын ажил дуусаагүй тул тус багцад орсон Галшар сумын Оч багийн төвийн барилгыг ашиглалтад авах техникийн комисс ажиллаагүй байна.

Мөн Хэрлэн суманд хийгдсэн авто зогсоолуудын хучилт ажлын зардал нэмэгдсэнээс гүйцэтгэгч компани төсөвт өртгийг нэмэгдүүлэх хүсэлт тавьснаас улсын комисс ажиллаагүй байна.

2023 онд Орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалтын 50 төсөл, арга хэмжээнд 10,680.7 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж жилийн эцсийн гүйцэтгэлээр 10,194.2 сая төгрөгийг олгосон байна.

Гүйцэтгэгчид 9,483.8 сая төгрөгийг, зураг төсвийн зардалд 407.9 сая төгрөгийг, зохиогчийн хяналтын зардалд 29.8 сая төгрөгийг санхүүжүүлж, гүйцэтгэсэн төсөл арга хэмжээний чанарын барьцаанд 226.1 сая төгрөгийг авч үлдсэн байна.

Харин тендерт шалгарсан хугацаанд мөрдөх календарчилсан төлөвлөгөөг мөрдөөгүйгээс гэрээний хугацаанд төсөл, арга хэмжээг гүйцэтгээгүй ... аж ахуйн нэгжээс гэрээний алдангид 24.5 сая төгрөгийг суутган авсан байна.

Эрүүл мэндийн багцад олгосон “Москит зажем” багаж 2 ширхгийг нийлүүлсэн боловч үнийн дүнг 100.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон.

Г.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг санхүүгийн тайланд бүрэн бүртгээгүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан 22 төсөл, арга хэмжээнд 2023 онд аймгийн Засаг даргын 2021 оны А/630 Захирамжаар батлагдсан албан тушаалтнуудыг оролцуулан улсын комиссыг ажиллуулсан байна.

Дээрх комиссыг албан тушаалаар нь томилсон бөгөөд өнгөрсөн хугацаанд зарим байгууллага татан буугдсан нь Захирамжийг өөрчилж шинэчлэн байгуулах зайлшгүй шаардлагатай байна.

Аймгийн Засаг даргын Захирамжид орсон аймгийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсан байна.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын актаар тухайн ажлын хадгаламжийн нэгжийг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөхийг гүйцэтгэгчид үүрэг болгодог боловч үүнд тавих хяналт хангалтгүйгээс хэрэгжилтийг орхигдуулсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжсэн 20,906.5 сая төгрөгийн 48 төсөл, арга хэмжээнээс 19,538.8 сая төгрөгийн 37 төсөл, арга хэмжээг санхүүгийн тайланд бүртгэсэн бол 10 төсөл, арга хэмжээний 1,376.7 сая төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайлан бүртгэлд тусгаагүй байна. Харин 9.0 сая төгрөгийг 1 төсөл, арга хэмжээнд илүү бүртгэсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын 11 төсөл, арга хэмжээний 1,568.7 сая төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайлан бүртгэлд тусгаагүй байна. Харин 9.0 сая төгрөгийг 1 төсөл, арга хэмжээнд илүү бүртгэсэн байна.

Нийт нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй төсөл, арга хэмжээнээс 4 нь улсын комиссын акт болон бусад баримт бичиг ирээгүй тул, 5 нь зураг төсвийн ажлыг бүртгэх шийдвэр гараагүй, 1 нь ТӨБЗГ-аас шийдвэр ирээгүй, бусад 2 төсөл, арга хэмжээ нь хувийн орон сууцанд оруулсан хөрөнгийг бүртгэх боломжгүй, үнийн дүнг өсгөн бүртгэсэн зэрэг шалтгаантай байна. /зөвлөмж-5/

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгагдсан давагдашгүй хүчин зүйл, хууль, журмын өөрчлөлт, санхүүжилт хугацаандаа олгогдохгүй байх, холбогдох зөвшөөрөл баримт бичгийг гаргаж өгөөгүй байх нөхцөлүүд үүсээгүй байхад гэрээг сунгасан нь төсөл, арга хэмжээ хугацаандаа ашиглалтад орохгүй байдалд хүргэж байна.
- Бүрэн хэрэгжиж дуусаагүй болон гүйцэтгэл хангалтгүй 4 төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулсан байна.
- Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан журам, ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн дагуу барилга, байгууламжийн зураг төсөл, баримт бичгийг ашиглагч талд хүлээлгэн өгөөгүй, хөрөнгөд бүртгэх чиглэлд төсөв болон бүртгэх байгууллага тодорхой бус байгаагаас 25 ажлыг санхүүгийн тайланд бүрэн бүртгээгүй байна.
- Зарим төсөл, арга хэмжээний зураг төслийг иж бүрэн төлөвлөөгүй, батлагдсан төсөвт өртөгт багтаан зураг төслөөс зарим ажлыг хасаж хэрэгжүүлсэн байна.
- Батлагдсан гүйцэтгэлийн дагуу холбогдох баримтыг үндэслэн хяналтын зардлын санхүүжилтийг бүрэн олгоогүй байна.
- Төсөл арга хэмжээнд тавих хяналт хангалтгүй, тендерт шалгарсан гүйцэтгэгч байгууллага календарчилсан төлөвлөгөөг мөрдөж ажиллахгүй байгаагаас шалтгаалан зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширч байна.
- Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан журмын 7.4 дэх хэсгийг баримталж барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын гишүүдийг бүрэн бүрдүүлж ажиллахгүй байна,
- Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан журмын 7.6 дахь хэсэгт заасны дагуу комиссын гишүүд өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг бүрэн шалгаж баталгаажуулахгүй байна.
- Байнгын ашиглалтад хүлээн авсан зарим төсөл, арга хэмжээний ашиглалт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Ц.Чогсомжав-д:

- Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгаагүй нөхцөлөөр гэрээг сунгахгүй байх,
- Төсөл, арга хэмжээний зураг төслийг иж бүрэн төлөвлөж, батлуулж, хэрэгжүүлдэг байх,
- Батлагдсан гүйцэтгэлийн дагуу холбогдох баримтыг үндэслэн хяналтын зардлын санхүүжилтийг тухай бүр бүрэн олгож байх,
- Байнгын ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээг бүрэн ашигладаг байх

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Г.Лхагвахатан-д:

- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээг бүртгэх байгууллагыг тодорхой болгох, холбогдох баримт бичгийг хүргүүлж өмчид бүртгэх ажлыг зохион байгуулж хяналт тавьж ажиллах

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Б.Сүнгээ-д:

- Төсөл, арга хэмжээнд тавих захиалагчийн хяналтыг үр дүнтэй хийж, зураг төсөвт тусгагдсан ажлуудыг бүрэн дуусган улсын комисс ажиллах, үүрэг даалгаврын биелэлтийг бүрэн хангуулах,
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн дагуу улсын комиссыг бүрэн бүрэлдэхүүнтэй ажиллуулах зохион байгуулалтыг хийх,
- Тендерт шалгарсан гүйцэтгэгчээр календарчилсан төлөвлөгөөг мөрдүүлж төсөл, арга хэмжээг хугацаанд нь дуусгаж байх
- Төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссаны дараа улсын комисс хүлээн авдаг байх

Үндэсний аудитын газарт хүргүүлэх санал:

Эрх шилжиж ирээгүй дараах төсөл, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хөндлөнгийн шинжээч ажиллуулах саналтай байна. Үүнд:

- Өмнөдэлгэр сумын Соёлын төвийн барилгын хананд их хэмжээний цууралт өгсөн,

- Батноров сумын ЕБС-ын барилгын хаалгыг зураг төсөвт тусгаснаас өөрчилснөөс босготой болсон нь хүүхдүүд орж гарахад хүндрэлтэй болсон, спорт залны цонхны материалыг өөрчилж вакум цонх болгосон,
- Хэрлэн сумын 1 дүгээр багийн дундуур тавьсан А0501 дүгээр зам нь дуусаагүй байхдаа эвдрэл өгсөн
- Өмнөдэлгэр сумын уурын зуухны барилга 2020 онд ашиглалтад орсон боловч ашиглалтын шаардлага хангахгүй болсон,

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 04 дугаар сарын 18

Дугаар А/09

Чингис хот

Аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйл, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, МУЕА-ын “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар тогтоосон төлбөрийн актыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, Засаг даргад тус тус хүргүүлэхийг ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т үүрэг болгосугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, түүний биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Ц.Чогсомжав), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Б.Сүнгээ), Орон нутгийн өмчийн газар (Г.Лхагвахатан) нарт, тогтоосон төлбөрийн актыг хэрэгжүүлэн, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Ц.Чогсомжав)-д, тус тус зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Д.Оюунтуяа/-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Ж.ГАНБААТАР



232410018

АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛ

Аудитын нэр:
Аудитын код:

Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн
ХЭА-2024/18-22-ШТА-ГА

Байгууллагын нэр: Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар

№	Аудитын чиглэл, асуулт	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалтагдагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
Аудитын дэд зорилт А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн үү?						
A.1.	Төсөл, арга хэмжээний зураг төсөл, ажлын даалгавар, техникийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрмийн дагуу төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан үү?					
A.1.3.	Зураг төслийг иж бүрэн боловсруулсан үү?	Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Хэнтий, Батширээт/, төсөл арга хэмжээ нь анх зураг төслийг боловсруулахдаа гадна тохижилтыг орхигдуулсан байна.		ЗӨВЛӨМЖ: Зураг төслийг иж бүрэн боловсруулсан эсэхийг сайтар нягтлах		
A.3.	Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон үү?					
A.3.1.	Ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон үү?	Аймгийн захиалагчийн хяналтын зардлын данснаас 7 төсөл, арга хэмжээний 200.0 сая төгрөгийг аймгийн бусад орлогын дансанд төвлөрүүлсэн байна. 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар аймгийн захиалагчийн хяналтын зардлын дансанд захиалагчийн хяналтын 69.8 сая төгрөг, зохиогчийн хяналтын 66.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.	136,630,441.0	ТӨЛБӨРИЙН АКТ: Захиалагчийн хяналтын зардлын дансанд байгаа захиалагчийн хяналтын 69.8 сая төгрөг, зохиогчийн хяналтын 66.8 сая төгрөгийг төвлөрүүлэх	<i>Гэрээний дагуу 144,444,444.44 төгрөг байгаа тул ЗӨВЛӨМЖ-ийн дагуу 300,000,000.00 төгрөг зэрэг илэрсэн</i>	
A.3.2.	Санхүүжилтийг хугацаанд нь бүрэн шилжүүлсэн үү?	Нормчлолын сангийн зардлыг гүйцэтгэл бүрд баталгаажуулж байгаа хэдий ч тус сангийн зардлыг тухай бүр шилжүүлэхгүйгээр оны эцэст бөөнд нь шилжүүлэх байдал төсөл, арга хэмжээ бүрд байна.		ЗӨВЛӨМЖ: Батлагдсан гүйцэтгэлийн дагуу холбогдох баримтыг үндэслэн санхүүжилтыг төрөл тус бүрээр бүрэн олгож байх		
Дэд зорилт Б. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хүлээн авсан үү?						
B.1.	Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хэрэгжүүлсэн үү?					
B.1.1.	Төсөл, арга хэмжээ нь гэрээний хугацаанд бүрэн хэрэгжсэн үү?	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуйн нэгжтэй байгуулсан 10 гэрээг сунгасны 1 ажилд гүйцэтгэчийн албан хүсэлтээр, 3 ажилд Дэд бүтцийн ажлын зөвлөлийн шийдвэрээр, 6 ажилд төсвийн хөрөнгө оруулалтын журмыг ашиглажээ.		ЗӨВЛӨМЖ: Гэрээнд тусгагдсан нөхцлөөс бусад шалтгаанаар гэрээг сунгахгүй байх		
B.1.2.	Төсөл, арга хэмжээ нь холбогдох зургийн дагуу хэрэгжсэн үү?	Баянмөнх сумын Спорт цогцолборын барилтын агааржуулалт хийгдээгүй, шалны лахан давхаргыг будаагүй, волейбол болон сагсны тоглоолыг суурилуулаагүй, Өмнөдэлгэр сумын ЕБС-ын шинэ барилтын цахилгааны зарим розетгууд цахилгаанд холбогдоогүй, угаалтуурын холбогчууд сул холбосон, биеийн тамирын залны таазнаас дусаал гоождог, Дэлгэрхаан сумын Цэвэр усны эх үүсвэрийн худгийг хамгаалалтын хашааны гадна гаргасан зэрэг зөрчлүүд илэрсэн.		ЗӨВЛӨМЖ: Зураг, төсөвт тусгагдсан ажлуудыг бүрэн дуусгаж байх,		
B.2.	Төсөл, арга хэмжээнд хууль тогтоомж, заавар журмын дагуу бүх шатны хяналтыг хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан үү?					
B.2.1.	Төсөл арга хэмжээнд гэрээний хугацаанд улсын комисс ажиллуулах талаар хүсэлтэй ирүүлсэн үү?	Төсөл, арга хэмжээний гэрээний дуусах хугацаа болон бүтээн байгуулалтын дуусах хугацаа зэргийг гэрээнд тусд нь тусгаагүйгээс санхүүжилтийг бүрэн олгохын тулд хугацаандаа дуусаагүй 13 төсөл, арга хэмжээний гэрээг сунгасан байна.		ЗӨВЛӨМЖ: Худалдан авах ажиллагаанд шалгарсан хугацаанд төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж байх		

	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисст эрчим хүчний хяналтын улсын байцаагч, ХБИ-ийн төлөөлөл, архивын тасгийн ажилтан, барилга техникийн хяналтын улсын байцаагч нар 6-14 төсөл, арга хэмжээнд ажиллаагүй байна.		ЗӨВЛӨМЖ: Улсын комиссын бүрдүүлж ажиллах	
B.2.2. Улсын комиссын бүрэлдэхүүн бүрэн бүрдэж ажилласан уу?	Бэрх тосгоны ЕБС-ын сагсны талбайг будах, ус зайлуулах суваг хийх, ногоон байгууламж хийх, Баянмөнх сумын спорт цогцолборын шалыг лагдах болон волейболын тор суурилуулах, сагсны шийд байрлуулах ажил хийгдээгүй байна.		ЗӨВЛӨМЖ: Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн дуусгаж байх	
B.3. Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан уу?	Аймгийн ОНӨГ-аас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээг санхүүгийн тайланд бүртгэх бодох бүртгэлд тусгах талаар эрх зүйн баазтай байгаа боловч бүхий байгууллагын шийдвэр гарсан үү?		ЗӨВЛӨМЖ: Нийт төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн бүртгэх	
B.3.3. Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгасан уу?	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 28,985.8 сая төгрөгийн дүнтэй 14 төсөл, арга хэмжээг дутуу буюу бүрэн бүртгэл тусгаагүй байна.		ЗӨВЛӨМЖ: Улсын төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг орон нутгийн өмчид бүрэн бүртгэх	
Дэд зорилт В. Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?				
V.1. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна уу?	Ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарсан төсөл арга, хэмжээнээс гүйцэтгэл хангалтгүй хийгдсэн Баянмөнх сумын спорт цогцолборын барилгын агааржуулалтын систем, шалны лаван давхрага хийгдээгүй, Өмнөдэлгэр сумын ЕБС-ийн цахилгааны залгуурын холболт дутуу хийгдсэн, угаалтуурын холболтуудыг сул холбосон, Дэлгэрхаан сумын цэвэр усны эх үүсвэрийн худаг хамгаалалтын хашааны гадна гарсан, Бэрх тосгоны далд уурхай өргөх цахилгаан шатны гүйцэтгэлийн зураг баталгаажуулалт хийгдээгүй, Биндэр сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын гадна цахилгаан зэргийн гүйцэтгэл хангалтгүй хийгдсэнээс ашиглалтад сөргөөр нөлөөлж байна.		ЗӨВЛӨМЖ: Захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх	
V.1.1 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл үр дүнтэй байна уу?			ЗӨВЛӨМЖ: Хэрэгжиж дууссан ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарсан төсөл арга хэмжээг бүрэн ашиглах	
V.1.2. Төсөл арга хэмжээг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна уу?	Бүрэн хийгдэж дууссан 30 төсөл, арга хэмжээнээс 6 төсөл, арга хэмжээг бүрэн хүчин чадлаар нь ашиглахгүй байна.		ЗӨВЛӨМЖ: Төсөл арга хэмжээний ачаа холбогдлыг эрэмбэлж тооцох	
V.2. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангах, төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?	Өмнөдэлгэр сумын ЕБС-ийн барилгын ажлыг төлөвлөхдөө ширээ сандлыг оруулаагүй нь сургуулийн 3 давхарын ашиглалтын үр өгөөжийг бууруулж байна. Эрх шилжээгүй Батноров сумын ЕБС-ийн барилгыг анх төлөвлөхдөө спорт заал, урлаг заалны тавилга тоног төхөөрөмжийг бүрэн оруулж төлөвлөгөөгүйгээр хөрөнгө оруулалтын өгөөж буурч байна.		ЗӨВЛӨМЖ: Төсөл арга хэмжээний ачаа холбогдлыг эрэмбэлж тооцох	
V.2.3. Төсөл, арга хэмжээ нь хэрэгцээ шаардлагыг хангаж төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?	Дэлгэрхаан, Жаргалтхаан Өмнөдэлгэр сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах даалгаварт тусгасан аж ахуйн нэгж, төрийн байгууллагууд руу цэвэр ус холбох ажил хийгдээгүй байна.		ЗӨВЛӨМЖ: Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хүрэх дүнг бодитой тооцох	

Дэд зорилт Г. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй байна уу?			
Г.3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт нь үр дүнтэй байна уу?			
Г.3.2. Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, бүртгэсэн үү?	Орон нутгийн хөрөнгө оруулалтын 11 төсөл, арга хэмжээний 1,568.7 сая төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайлан бүртгэлд тусгаагүй байна. Харин 9.0 сая төгрөгийг 1 төсөл, арга хэмжээнд илүү бүртгэсэн байна.		
НИЙТ ДҮН		136,630,441.0	

Бэлтгэсэн:

Аудитор:

Ахлах аудитор:

Ахлах аудитор:

Анхан шатанд хянасан:

Аудитын менежер:

Хоёр дахь шатанд хянасан:

Дарга, тэргүүлэх аудитор:

Танилцсан:

Огноо 2024.04.11

Огноо 2024.04.11

Огноо 2024.04.11

Огноо 2024.04.11

Огноо 2024.04.11

С.Нямдаваа

Х.Баярбаатар

Э.Мөнх-Эрдэнэ

Ц.Бат-Эрдэнэ

Огноо 2024.04.11

Огноо 2024.04.11

Огноо 2024.04.11

Огноо 2024.04.11



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 73/А2341113

Чингис хот

ХЭА-2024/18-12-ШТА-ГА.

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээний гүйцэтгэл ирүүлээгүй хугацаа хэтэрсэн захиалагч болон зохиогчийн хяналтын 136,630,441.0 төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд байршуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.”, 45 дугаар зүйлийн 45.2 “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Захиалагчийн хяналтын дансанд байршиж байгаа захиалагч болон зохиогчийн хяналтын 136,630,441.0 төгрөгийг Төрийн сан банкин дахь “Нэр заагдаагүй бусад орлого” 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг
3. Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга С.Нямдаваа-д даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АХЛАХ АУДИТОР

Ц.БИЛЭГСАЙХАН



232450218

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112